

**Магадлан итгэмжлүүлэх
хүсэлт гаргах, материал
бүрдүүлэлт**

Материал бүрдүүлэлт

- Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргах эрүүл мэндийн байгууллага нь Эрүүл мэндийн сайдын 2014 оны 07дугаар сарын 18-ны өдрийн “Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 237дугаар тушаалын хавсралтаар баталсан журмын 4.1-д заасан дагуу дараах материалыг бүрдүүлнэ.
Үүнд:

1.Магадлан итгэмжлэлд хамрагдах тухай албан хүсэлт

- Хүсэлт гаргаж буй албан бичиг нь албан хэрэг хөтлөлтийн стандартын шаардлагыг хангасан байх;
- Албан бичгийн огноо нь материал ирүүлсэн **хугацаатай** тохирч байх

- Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 499 дугаар тушаалын 1-р хавсралтаар батлагдсан “Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргаж буй эрүүл мэндийн байгууллагын танилцуулга” (Маягт №01)-ийг хөтөлж ирүүлнэ.
- Анхаарах нь:
 - Давуу тал
 - Сул тал
 - Тухайн хугацаанд гарсан ахиц-дэвшил
 - Тухайн жилүүдийн Чанарын үзүүлэлтийн хөдөлгөөн

2. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар

- хуулбарыг ирүүлэх.
- Хэрэв тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хугацаа дууссан бол **сунгуулсан**, ажлын байр өөрчлөгдсөн бол одоо байрлаж байгаа **хаягийн өөрчлөлтийг** хийлгэсэн байх шаардлагатай.
- Тодорхой шалтгаанаар зөвшөөрлийн гэрчилгээний сунгалт хийгдээгүй бол **сунгагдаагүй шалтгааныг тодорхойлсон** аймаг, нийслэлийн ЭМГ, тусгай зөвшөөрлийн комиссын **албан бичиг, тодорхойлолтыг** хавсаргана.

- Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгээ сүүлийн 2 жилийн дотор сунгуулсан бол өмнөх гэрчилгээний хуулбарыг материалд хавсаргаж ирүүлнэ.
- Эрүүл мэндийн байгууллага нь **тусгай зөвшөөрөл авсан бүх мэргэжлийн төрөл, чиглэлээр** тусламж үйлчилгээ үзүүлдэг байх шаардлагатай.

3.Магадлан итгэмжлэлийн батламжийн хуулбар

- Тухайн эрүүл мэндийн байгууллагад олгосон А4 хэмжээтэй /жижиг/ батламжийн хуулбарыг ирүүлнэ
- Анх удаа магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргаж буй байгууллагад хамаарахгүй.

4.Магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтээр хийсэн өөрийн үнэлгээний тайлан

- www.mohs.mn вэб хуудасны “Төрийн үйлчилгээ” линкийн “Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл” буланд байгаа “Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт”-ээр өөрийн үнэлгээ хийх зөвлөмжийг ашиглаж тайланг бичнэ.

Анхаарах нь:

- **Бодитой, үнэн байдлаа шударга, зөв үнэлнэ. Doу; 100 биш!!!**
- **Заавал бичих гэж хамаатуулахгүй!!!** (Байгаа бол байгаа, байхгүй бол байхгүй)
- **Сайтар уншинаа!!!**

Тусламж үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөр

- ЭМЯ-ны Эрүүл мэндийн байгууллагын удирдлага, хөгжлийн хэлтэс, ЭМСЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газар /хуучнаар/баталгаажуулж магадлан итгэмжлэлийн хугацаанд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хуулбарыг тайлангийн хамт ирүүлнэ. Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж, **хувиар** тооцож үнэлэлт дүгнэлт өгнө.

Чанарын хөгжлийн хөтөлбөрийн тайлан бичих загвар:

..... эмнэлгийн чанарын хөгжлийн
хөтөлбөр/төлөвлөгөө /-ийн тайлан

Хэрэгжүүлсэн хугацаа:..... оны сарын
өдрөөсоны сарын –ны өдөр

1-р зорилтын хүрээнд: /өөрийн байгууллагын дэвшүүлсэн зорилтыг бичих

№	Төлөвлөсөн үйл ажиллагаа	Хүрсэн үр дүн шалгуур үзүүлэлтийн биелэлт	Хэрэгжилт
1		Зорьсон үр дүндээ хүрсэн талаар	Товч, тодорхой Баримт нотолгоотой Дүгнэлт хийсэн
2			
Хэрэгжилтийн хувь			

5. Шинжээчдийн өгсөн зөвлөмж

.....эмнэлэгт магадлан итгэмжлэлийн
шинжээчдийн өгсөн зөвлөмжийн **биелэлт-хувиар**

Зөвлөмж өгсөн онсар ... өдөр

№	Шинжээчдийн өгсөн зөвлөмж	Зөвлөмжийн биелэлт
	Удирдлага бүтэц зохион байгуулалт	
1		



Шинжээчдийн өгсөн зөвлөмж

№	Шинжээчдийн өгсөн зөвлөмж	Зөвлөмжийн биелэлт
Тусламж үйлчилгээний технологийн мөрдөлт		
1		
2		
Эрүүл ахуйн нөхцөл , халдварын сэргийлэлт, хяналт , техникийн үйлчилгээ		
1		
2		
Хэрэгжилтийн хувь		

6.Тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтүүд

- Өөрийн байгууллагын баталж, хэрэгжүүлж буй чанарын үзүүлэлтүүдийн **баталгаажсан хувь** /үйл ажиллагааны болон эрүүл мэндийн статистик үзүүлэлт гэх мэт/
- Чанарын үзүүлэлтүүдийг /МИ хугацааны/**харьцуулсан үнэлгээ** өгч, дүгнэлт бичсэн байна

Нуруулдах:



Анхаарал тавьсанд баярлалаа

